БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/77/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Булган аймаг<br>2022 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: П.Содном<br>Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ........................................................ **Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................ 5

3. Аудитын тайлан ........................................................ 13

   3.1 Ерөнхий зүйл ........................................................ 13

   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................ 13

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................ 14

   3.4 Материаллаг байдал ........................................................ 14

   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................................ 14

   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................................ 15

   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................................ 16

   3.8 Аудитын гол асуудал ........................................................ 16

   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................................ 16

   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................................ 17

   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................ 17

4. Аудитын илрүүлэлт ........................................................ 17

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 57

танай______________ны №______________т

ТЭШИГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ С.СҮНЖИДМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020055

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **138,642,019.81** | **148,919,791.21** |
| **33** | **АВЛАГА** | - | 13,000,000.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 13,000,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 13,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 138,642,019.81 | 135,919,791.21 |
| **354** | **Хангамжийн материал** | 138,342,019.81 | 135,619,791.21 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,425,943.74 | 4,413,463.74 |
| 35420 | Аж ахуйн материал | 95,839,244.13 | 96,534,344.13 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,000,000.00 | 1,750,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,335,729.10 | 3,027,880.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 29,741,102.84 | 29,894,102.84 |
| 35600 | Мал амьтад | 300,000.00 | 300,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,078,621,652.39** | **2,003,811,029.12** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,078,621,652.39 | 2,003,811,029.12 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,985,920,712.39 | 1,911,447,589.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,886,642,677.23 | 1,886,642,677.23 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (48,877,499.82) | (99,220,415.74) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 100,939,690.24 | 117,497,390.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (50,371,971.28) | (84,301,556.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 132,091,567.97 | 134,636,367.97 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (48,291,156.39) | (63,031,409.28) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,354,038.70 | 10,354,038.70 |
| 39217 | Ном | 3,433,365.74 | 8,870,496.49 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 92,700,940.00 | 92,363,440.00 |
| 39301 | Програм хангамж | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (337,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 91,100,940.00 | 91,100,940.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,217,263,672.20** | **2,152,730,820.33** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,217,263,672.20** | **2,152,730,820.33** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,217,263,672.20 | 2,152,730,820.33 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,003,170,165.12 | 1,003,170,165.12 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 915,977,488.06 | 851,444,636.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 915,977,488.06 | 915,977,488.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (64,532,851.87) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 298,116,019.02 | 298,116,019.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,217,263,672.20** | **2,152,730,820.33** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,232,380,220.00** | **1,226,229,766.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,070,097,120.00** | **9,626,135.15** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,070,097,120.00 | 9,626,135.15 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,070,097,120.00 | 9,626,135.15 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,070,097,120.00 | 9,626,135.15 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,162,283,100.00** | **1,216,603,631.60** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,004,669,700.00 | 1,013,474,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,004,669,700.00 | 1,013,474,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,730,000.00 | 1,537,982.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,500,000.00 | 1,183,482.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 230,000.00 | 354,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 155,883,400.00 | 201,591,549.60 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 155,883,400.00 | 201,591,549.60 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,217,093,555.23** | **1,290,762,618.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,217,093,555.23** | **1,290,762,618.62** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,098,619,868.32 | 1,234,945,874.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 750,054,681.00 | 783,985,389.36 |
| 210101 | Үндсэн цалин | 506,660,709.00 | 525,787,388.36 |
| 210102 | Нэмэгдэл | 176,471,914.00 | 193,904,380.00 |
| 210104 | Урамшуулал | 66,922,058.00 | 64,293,621.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 93,056,249.54 | 103,101,780.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,102,992.15 | 72,593,594.53 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,775,056.16 | 7,621,294.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,143,359.09 | 6,115,156.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,344,308.74 | 1,524,839.52 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,690,533.40 | 15,246,894.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 153,481,564.65 | 200,841,549.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,890,283.00 | 6,355,405.00 |
| 210302 | Түлш, халаалт | 140,291,852.00 | 185,285,760.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,299,429.65 | 9,200,384.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,266,426.05 | 10,292,156.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 593,161.05 | 1,183,956.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,929,260.00 | 2,883,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 493,205.00 | 650,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 209,600.00 | 162,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,436,300.00 | 1,535,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,062,900.00 | 3,876,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,542,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 25,671,282.70 | 24,546,465.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 376,900.00 | 434,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,642,082.70 | 20,737,265.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 652,300.00 | 3,375,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,005,000.00 | 1,267,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 103,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,005,000.00 | 1,164,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 885,500.00 | 1,828,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 885,500.00 | 1,828,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,993,780.00 | 605,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,669,780.00 | 605,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,205,384.38 | 108,477,834.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 230,000.00 | 4,482,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,788,292.00 | 4,644,780.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 51,187,092.38 | 99,350,254.02 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 118,473,686.91 | 55,816,743.86 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,311,765.10 | 23,381,162.90 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,111,765.10 | 22,781,162.90 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 99,010,586.46 | 32,435,580.96 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 99,010,586.46 | 32,435,580.96 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 151,335.35 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 151,335.35 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,015,286,664.77** | **(64,532,851.87)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 648,686.53 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 648,686.53 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (648,686.53) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,014,637,978.24** | **(64,532,851.87)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,003,170,165.12 | 298,116,019.02 | (148,753,940.23) | 1,152,532,243.91 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,003,170,165.12** | **298,116,019.02** | **(148,753,940.23)** | 1,152,532,243.91 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 1,064,731,428.29 | 1,064,731,428.29 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,003,170,165.12** | **298,116,019.02** | **915,977,488.06** | 2,217,263,672.20 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,003,170,165.12** | **298,116,019.02** | **915,977,488.06** | 2,217,263,672.20 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,003,170,165.12** | **298,116,019.02** | **915,977,488.06** | 2,217,263,672.20 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (64,532,851.87) | (64,532,851.87) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,003,170,165.12** | **298,116,019.02** | **851,444,636.19** | 2,152,730,820.33 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,181,479,640.00** | **1,218,931,337.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,196,540.00** | **2,327,706.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 19,196,540.00 | 2,327,706.00 |
| 120009 | Бусад орлого | 19,196,540.00 | 2,327,706.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,162,283,100.00** | **1,216,603,631.60** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,004,669,700.00 | 1,013,474,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,004,669,700.00 | 1,013,474,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,730,000.00 | 1,537,982.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,500,000.00 | 1,183,482.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 230,000.00 | 354,500.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 155,883,400.00 | 201,591,549.60 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 155,883,400.00 | 201,591,549.60 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,171,825,640.00** | **1,203,054,837.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,171,825,640.00** | **1,203,054,837.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,056,185,667.19** | **1,147,533,716.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 744,217,236.00 | 783,985,389.36 |
| 210101 | Үндсэн цалин | 500,823,264.00 | 525,787,388.36 |
| 210102 | Нэмэгдэл | 176,471,914.00 | 193,904,380.00 |
| 210104 | Урамшуулал | 66,922,058.00 | 64,293,621.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 93,056,249.54 | 103,101,780.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,102,992.15 | 72,593,594.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,775,056.16 | 7,621,294.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,143,359.09 | 6,115,156.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,344,308.74 | 1,524,839.52 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,690,533.40 | 15,246,894.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 154,727,064.65 | 200,591,549.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,935,783.00 | 6,355,405.00 |
| 210302 | Түлш, халаалт | 141,491,852.00 | 185,035,760.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,299,429.65 | 9,200,384.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,819,465.00 | 9,934,352.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 486,800.00 | 1,276,602.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,929,260.00 | 2,883,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 493,205.00 | 650,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 402,800.00 | 270,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,069,300.00 | 1,840,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,438,100.00 | 3,013,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,705,800.00 | 23,779,145.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 421,900.00 | 592,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 28,242,100.00 | 20,052,745.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,041,800.00 | 3,134,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,005,000.00 | 14,457,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 13,103,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,005,000.00 | 1,354,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 885,500.00 | 1,828,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 885,500.00 | 1,828,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,543,780.00 | 605,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,219,780.00 | 605,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,225,572.00 | 9,250,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,356,000.00 | 3,778,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,869,572.00 | 5,472,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **115,639,972.81** | **55,521,121.46** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,478,051.00 | 23,085,540.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,278,051.00 | 22,485,540.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 99,010,586.46 | 32,435,580.96 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 99,010,586.46 | 32,435,580.96 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 151,335.35 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 151,335.35 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,654,000.00** | **15,876,500.00** |
| 140008 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,654,000.00** | **15,876,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,654,000.00** | **15,876,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,654,000.00 | 15,876,500.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 8,304,000.00 | 13,351,500.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,350,000.00 | 2,525,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(9,654,000.00)** | **(15,876,500.00)** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1221708500.00 | 1184957774.64 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1221708500.00 | 1184957774.64 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1189405700.00 | 1161872234.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 786302600.00 | 784751676.00 |
| 210101 | Үндсэн цалин | 526746200.00 | 526553675.00 |
| 210102 | Нэмэгдэл | 194820700.00 | 193904380.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 64735700.00 | 64293621.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 104990700.00 | 102335493.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73778700.00 | 71827307.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7733000.00 | 7621294.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6312400.00 | 6115156.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1560600.00 | 1524839.52 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15606000.00 | 15246894.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 207234400.00 | 200591549.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8085900.00 | 6355405.00 |
| 210302 | Түлш, халаалт | 187883400.00 | 185035760.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11265100.00 | 9200384.60 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8935100.00 | 8878870.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 483200.00 | 483120.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2922100.00 | 2883550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 679,400.00 | 650,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 386,700.00 | 398,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,450,500.00 | 1,450,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,013,200.00 | 3,013,200.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 40,031,100.00 | 23,779,145.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 592,800.00 | 592,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 36,304,100.00 | 20,052,745.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,134,200.00 | 3,134,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,020,000.00 | 22,019,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,300,000.00 | 20,299,800.00 |
| 210602 | Тавилга | 720,000.00 | 720,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,983,200.00 | 1,828,200.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,983,200.00 | 1,828,200.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 820,200.00 | 605,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 820,200.00 | 605,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,088,400.00 | 17,082,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,000,000.00 | 11,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,088,400.00 | 6,082,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 32,302,800.00 | 23,085,540.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 32,302,800.00 | 23,085,540.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,702,800.00 | 22,485,540.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 600,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,221,708,500.00 | 1,217,393,355.60 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,013,474,100.00 | 1,013,474,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,013,474,100.00 | 1,013,474,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 208,234,400.00 | 201,591,549.60 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 208,234,400.00 | 201,591,549.60 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 2,327,706.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 2,327,706.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 65.00 | 65.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 42.00 | 42.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 22.00 | 22.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 654.00 | 654.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 654.00 | 654.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 654.00 | 654.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **65.00** | **65.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 43.00 | 43.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 22.00 | 22.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **1,537,982.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **1,537,982.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 1,537,982.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 1,183,482.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 793,482.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 390,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 354,500.00 |
| 210604 | Урсгал засвар | | 354,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 1,537,982.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 1,537,982.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,183,482.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 354,500.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, өглөг үүсгэхгүй байхгүй, анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд 65 орон тоотойгоор сургалт хүмүүжлийн болон бусад үйл ажиллагаагаа явууллаа. Үүнээс захирал 1, сургалтын менежер 2, нийгмийн ажилтан 1, багш 34, байрны багш 2, ажилчин 25, багш ажилчдын 80 хувь эмэгтэй, 20 хувь эрэгтэй ажилчин эзэлж байна.

Удирдах ажилтан, багш нарын 80 хувь мэргэжлийн зэрэгтэй бөгөөд үүнээс тэргүүлэх 16, заах аргач зэрэгтэй 12 багш байна.

Энэ хичээлийн жилд бага ангийн, ахлах дунд ангийн заах аргын нэгдэл, захиргаа, аж ахуй, дотуур байр гэсэн бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр 655 суралцагчдад боловсролын үйлчилгээг үзүүлж байна. Сургуулийн дотуур байранд нийт суралцагчдын 16 хувь нь хамрагдаж байгаа бөгөөд бага ангиас 42, дунд ангиас 46, ахлах ангиас 19 суралцагч байна.

Энэ хичээлийн жилд “Сэргэлэн цовоо, саруул ухаантай, суралцагч хүүхэд” гэсэн зорилгыг тавин ажиллажээ.

Дээрх зорилтын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлжээ.

1. Суралцагчид өөрийгөө илэрхийлэх, ухаарч ойлгох чадварыг хөгжүүлэх,гэр бүлийн орчинд хамтран суралцахад дэмжлэг үзүүлэх.
- Багш, ажилтан, ажилчид ээлжит хичээлийн чанар, үр өгөөж, хамтран хөгжих, эрсдэлгүй, эрүүл орчинг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нөлөөтэй байна. Тус байгууллага нь 2021 онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам шинэчлэн баталж, жилийн ажлын төлөвлөгөө, график гарган ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1217.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тэшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.4 сая төгрөгөөр өссөн нь авлага, үндсэн хөрөнгө, бараа материал өссөнтэй холбоотой байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг /

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | - | 13,000.00 | 13,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 138,642.02 | 135,919.79 | (2,722.23) |
| Үндсэн хөрөнгө | 2,078,621.65 | 2,003,811.03 | (74,810.62) |
| **Нийт хөрөнгө** | 2,217,263.67 | 2,152,730.82 | (64,532.85) |
| **Өглөг** | - | - | - |
| Хуримтлагдсан үр дүн | 915,977.49 | 851,444.64 | (64,532.85) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 2,217,263.67 | 2,152,730.82 | (64,532.85) |

**Авлага:** Тайлант онд шинээр 13.0 сая төгрөгийн авлага өссөн нь оны эцэст төсөвт зохицуулалт хийснээр цахим самбар худалдан аваах гэрээг хийж 2022 оны 01 дүгээр сарын 31-нд бараа нийлүүлэхээр гэрээнд тусгаж санхүүжилтийг олгосноор авлага үүссэн байна.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 138.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 135.9 сая төгрөг болж өмнөх оноос 2.7 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 66.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 64.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 1.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Нийт 69.1 сая төгрөгийн бараа материал хасагдсанаас 66.1 сая төгрөг зарцуулж, хүнсний материал дээр цар тахалтай холбоотой сургалтын үйл ажиллагаанд өөрчлөлт орсон учир нийт 2.3 төгрөгийн хүнсний материалыг зарж борлуулан үндсэн дансанд төвлөрүүлснийг санхүүгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бусад орлогоор бүртгэсэн байна. Мөн багш нарыг витаминжуулалт гэж нийт 0.3 сая төгрөгийн чацаргана, элсэн чихрийг захирлын тушаалаар зарцуулж, үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталж устгасан хөрөнгө байхгүй байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2226.2 сая, эцсийн үлдэгдэл 2250.7 сая төгрөг болж өмнөх оноос 24.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 15.9, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 8.7 сая төгрөгийн нь Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яамнаас 2.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 3.6 сая төгрөгийн түрээсийн ном, орон нутгийн хөгжлийн сангаас 2.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдэж орлогод авсан байна. Үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталж устгасан хөрөнгө байхгүй байна.

**Өр төлбөр:** Өр төлбөр данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээнд зориулан 1221.7 сая төгрөгийн төсөв баталснаас 1013.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 208.2 төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1013.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 201.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, 118.5 сая төгрөгийг зарцуулж 32.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 118.5 сая төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 1.5, норматив зардлаас хүнс 16.2, үдийн цай 9.2 тогтмол зардал 6.6 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 1.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүнд: БСУГ-аа 2021 оны 10 сард хийгдсэн үнэлгээний шалгалтын бичиг хэргийн материалын зардал 0.3, мөн ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал 0.4, дотуур байрны хүүхэд хөгжлийн төвд иргэнээс 0.5 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүнд, төсвийн байгууллагын өөрийн орлогын хүрээнд заалны орлого 0.4 сая төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 3 хувиар буюу 32.4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт 6.6 сая төгрөг буюу 3.2 хэмнэлт гаргасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээлэл байршуулахаас төсвийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д

"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас 11000000 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 13000000 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
- Тайлант хугацаанд нийт 1592330 төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

### 3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны аудитаар нийт 17726.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8542.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 315.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 8000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 869.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч хэрэгжилтийг бүрэн хангасан байна.

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 42.8 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 6.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 24.0 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгч, 11.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

### 4.1 Залруулсан алдаа

- Бараа материалын тайланд хүнснээс багш ажилчдад олгосон 0.4 сая төгрөгийн үнэ төлбөргүй зарцуулснаар бүртгэснийг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна. гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.
- Орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтээс хэмнэсэн 6.6 сая төгрөгийн санхүүжилтийг бууруулсан байхад төвлөрүүлэг шилжүүлгээр бүртгэснийг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2

дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна. гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

- Хоол, хүнсний зардлаас багш ажилчдад 335500 төгрөгийн хүнс зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал батлах тухай" заалтуудыг зөрчсөн зөрчил төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

- Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас 11000000 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, оны эцэст 13000000 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүйг зөрчилд албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

***1.1.*** *Илрүүлэлт:* Бусад үндсэн хөрөнгө дансанд 10.4 сая төгрөгийн ном бүртгэлтэй байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан 4.29-д "Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ыг дагаж мөрдөнө." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***1.2.*** *Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийн дансны ангиллыг зөв бүртгэж данс хооронд шилжүүлэх.

***2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой***

3.1 *Илрүүлэлт:* Тайлант хугацаанд нийт 1592330 төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

3.2 *Өгсөн зөвлөмж:* Худалдан авалт хийхдээ тухай бүр нь цахим И-баримтыг хангуулан бүртгэлд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | 6 | 22.2 | 1 | 1.3 | 1 | 0.1 | 1 | 20.9 | 3 | 0.2 |
| Дүн | | | | | | | | | | |